



МОНГОЛ УЛС  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2023 оны 02 сарын 01 өдөр

Дугаар 34

Улаанбаатар хот

Төрийн үйлчилгээний удирдах албан  
тушаалыг төрийн захиргааны  
албан тушаалын ангилалд адилтган авч үзэх  
албан тушаалын жагсаалт батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг, 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, Засгийн газраас ирүүлсэн саналыг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний удирдах албан тушаалыг төрийн захиргааны албан тушаалын ангилалд адилтган авч үзэх албан тушаалын жагсаалтыг 1 дүгээр, Мэргэжлийн боловсрол, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний удирдах албан тушаалыг төрийн захиргааны албан тушаалын ангилалд адилтган авч үзэх албан тушаалын жагсаалтыг 2 дугаар, Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний удирдах албан тушаалыг төрийн захиргааны төрийн захиргааны албан тушаалын ангилалд адилтган авч үзэх албан тушаалын жагсаалтыг 3 дугаар, Соёл, урлагийн салбарын төрийн үйлчилгээний удирдах албан тушаалыг төрийн захиргааны албан тушаалын ангилалд адилтган авч үзэх албан тушаалын жагсаалтыг 4 дүгээр, Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах төрийн үйлчилгээний удирдах албан тушаалыг төрийн захиргааны албан тушаалын ангилалд адилтган авч үзэх албан тушаалын жагсаалтыг 5 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2.Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.2-т заасан төрийн албаны тусгай шалгалт авах тохиолдолд төрийн захиргааны албан тушаалын түшмэлийн ангилалд тавигдах туршлагын шаардлагыг тооцохдоо энэхүү жагсаалтыг мөрдөн ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын алба, Салбар зөвлөлд үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, арга зүйн нэгдсэн удирдлага, зөвлөгөөгөөр хангаж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны дарга /Г.Билгүүн/-д даалгасугай.

ДАРГА



Б.БААТАРЗОРИГ

23000067

Төрийн албаны зөвлөлийн  
2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн  
34... дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ШИНЖЛЭХ УХААНЫ САЛБАРЫН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
УДИРДАХ АЛБАН ТУШААЛЫГ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ  
АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛД АДИЛТГАИ АВЧ ҮЗЭХ  
АЛБАН ТУШААЛЫН ЖАГСААЛТ

Төрийн захиргааны албан тушаалын ангилал	Төрийн үйлчилгээний удирдах албан тушаалын нэр
Тэргүүн түшмэл	- Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч;
Эрхэлсэн түшмэл	- Шинжлэх ухааны академийн дэд ерөнхийлөгч; - Эрдэмтэн нарийн бичгийн дарга
Ахлах түшмэл	- Шинжлэх ухааны академийн орлогч дарга; - Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга; - Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга; - Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал, дэд захирал; - Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төвийн дарга; - Шинжлэх ухааны паркийн захиргааны гүйцэтгэх захирал; - Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга
Дэс түшмэл	- Шинжлэх ухааны академийн хэлтсийн дарга; - Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн сектор, лабораторийн эрхлэгч; - Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн нэгжийн дарга; - Шинжлэх ухааны паркийн захиргааны хэлтэс, албаны дарга; - Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн төвийн лабораторийн эрхлэгч.



Төрийн албаны зөвлөлийн  
2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн  
34.. дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОН БАГА,  
ДУНД БОЛОВСРОЛ ЭЗЭМШҮҮЛЭХ СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН  
ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УДИРДАХ АЛБАН ТУШААЛЫГ ТӨРИЙН  
ЗАХИРГААНЫ АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛД АДИЛТГАН АВЧ ҮЗЭХ  
АЛБАН ТУШААЛЫН ЖАГСААЛТ

Төрийн захиргааны албан тушаалын ангилал	Төрийн үйлчилгээний удирдах албан тушаалын нэр
Ахлах түшмэл	<ul style="list-style-type: none"><li>- Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын захирал;</li><li>- Олон улсын хөтөлбөртэй сургуулийн захирал</li></ul>
Дэс түшмэл	<ul style="list-style-type: none"><li>- Ерөнхий боловсролын сургуулийн захирал /лаборатори болон тусгай сургууль мөн хамаарна/;</li><li>- Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын дэд захирал;</li><li>- Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын эрхлэгч</li></ul>
Туслах түшмэл	<ul style="list-style-type: none"><li>- Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын менежер;</li><li>- Олон улсын хөтөлбөртэй сургуулийн сургалтын менежер;</li><li>- Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежер.</li></ul>

Төрийн албаны зөвлөлийн  
2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн  
34 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
УДИРДАХ АЛБАН ТУШААЛЫГ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ  
АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛД АДИЛТГАН АВЧ ҮЗЭХ  
АЛБАН ТУШААЛЫН ЖАГСЛАЛТ

Төрийн захиргааны албан тушаалын ангилал	Төрийн үйлчилгээний удирдах албан тушаалын нэр
Эрхэлсэн түшмэл	- Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн дарга, захирал
Ахлах түшмэл	- Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн орлогч дарга, дэд захирал; - Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн захирал
Дэс түшмэл	- Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн дарга; - Дүүргийн эрүүл мэндийн төвийн дарга; - Дүүргийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төвтэй адилтгах байгууллагын дарга; - Аймгийн нэгдсэн эмнэлгийн орлогч дарга; - Дүүргийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төвийн орлогч дарга; - Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн алба, тасаг, нэгжийн эрхлэгч, албаны дарга; - Эмнэлгийн албаны дарга буюу эмнэлгийн чанарын болон хүний нөөцийн менежер
Туслах түшмэл	- Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн дарга; - Нэгдсэн эмнэлэг, тусгай эмнэлэг, амаржих газрын тасаг, нэгжийн эрхлэгч



Төрийн албаны зөвлөлийн  
2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн  
34 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт

СОЁЛ, УРЛАГИЙН САЛБАРЫН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
УДИРДАХ АЛБАН ТУШААЛЫГ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ  
АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛД АДИЛТГАН АВЧ ҮЗЭХ  
АЛБАН ТУШААЛЫН ЖАГСААЛТ

<b>Төрийн захиргааны албан тушаалын ангилал</b>	<b>Төрийн үйлчилгээний удирдах албан тушаалын нэр</b>
<b>Ахлах түшмэл</b>	<ul style="list-style-type: none"><li>- Үндэсний театр, эрдмийн театр, чуулгын захирал, уран сайхны удирдагч, ерөнхий найруулагч, ерөнхий удирдаач;</li><li>- Үндэсний номын сангийн захирал;</li><li>- Үндэсний музейн захирал;</li><li>- Соёлын өвийн үндэсний төвийн захирал</li></ul>
<b>Дэс түшмэл</b>	<ul style="list-style-type: none"><li>- Үндэсний театр, эрдмийн театр, чуулгын ерөнхий балетмейстер;</li><li>- Үндэсний номын сангийн нэгжийн дарга;</li><li>- Үндэсний музейн нэгжийн дарга;</li><li>- Соёлын өвийн үндэсний төвийн нэгжийн дарга;</li><li>- Дэлхийн өвийн дурсгалт газрын хамгаалалтын захиргааны дарга;</li><li>- Төв, орон нутгийн мэргэжлийн урлагийн байгууллагын дарга;</li><li>- Төв, орон нутгийн нийтийн номын сангийн захирал;</li><li>- Төв, орон нутгийн музейн захирал;</li><li>- Соёлын төв өргөөний захирал;</li><li>- Их сургуулийн номын сангийн захирал</li></ul>
<b>Туслах түшмэл</b>	<ul style="list-style-type: none"><li>- Соёлын өвийн үндэсний төвийн нэгжийн дарга;</li><li>- Дэлхийн өвийн дурсгалт газрын хамгаалалтын захиргааны нэгжийн дарга;</li><li>- Театр, чуулгын нэгжийн дарга;</li><li>- Төв, орон нутгийн номын сангийн нэгжийн дарга;</li><li>- Төв, орон нутгийн музейн нэгжийн дарга;</li><li>- Нийслэлийн дүүргийн номын сангийн эрхлэгч;</li><li>- Дээд боловсролын байгууллагын номын сангийн эрхлэгч;</li><li>- Соёлын ордон, соёлын төвийн дарга</li></ul>

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУСАД БАЙГУУЛЛАГА БОЛОН ТӨРИЙН  
БАЙГУУЛЛАГЫН ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХАД ТУСЛАХ УДИРДАХ  
АЛБАН ТУШААЛЫГ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛД  
АДИЛТГАН АВЧ ҮЗЭХ АЛБАН ТУШААЛЫН ЖАГСААЛТ

Төрийн захиргааны албан тушаалын ангилал	Төрийн үйлчилгээний удирдах албан тушаалын нэр
Эрхэлсэн түшмэл	- Төрийн өмчит их сургуулийн захирал, түүнтэй адилтгах бусад албан тушаал <sup>1</sup> .
Ахлах түшмэл	- Яамны эрхлэх асуудлын хүрээнд ажилладаг төрийн үйлчилгээний төсвийн байгууллагын дарга; - Үндэсний төв архивын захирал; - Төрийн өмчит их сургуулийн нэрэлдэхүүн сургуулийн болон дээд сургуулийн захирал, их сургуулийн дэд захирал; - Шинжлэх ухаан, технологийн сангийн захирал; - Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлийн ажлын албаны дарга; - Боловсролын зээлийн сангийн ажлын албаны дарга; - Боловсролын үнэлгээний төвийн захирал; - Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал.
Дэс түшмэл	- Яамны эрхлэх асуудлын хүрээнд ажилладаг төрийн үйлчилгээний төсвийн байгууллагын нэгжийн дарга; - Засгийн газрын агентлагийн эрхлэх асуудлын хүрээнд ажилладаг төрийн үйлчилгээний төсвийн байгууллагын дарга; - Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хэлтэс, төвийн дарга; - Шүүхийн эвлэрүүлэн зуучлагч, Шүүхийн төрөлжсөн архивын дарга; Их сургуулиудын эрдэмтэн нарийн бичгийн дарга; албаны дарга; төвийн захирал; нэгжийн эрхлэгч /төв, тэнхимийн эрхлэгч/; - Боловсролын үнэлгээний төвийн хэлтсийн дарга; - Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн захирал; - Нислэгийн цаг уурын төвийн дарга; - Аймаг, хотын Цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга; - Бүсийн төвийн менежер.

<sup>1</sup> Засгийн газрын 2023 оны 15 дугаар тогтоолын 1-т заасан.



<p><b>Туслах түшмэл</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>- Засгийн газрын агентлагийн эрхлэх асуудлын хүрээнд ажилладаг төсвийн байгууллагын нэгжийн дарга;</li> <li>- Улсын биеийн тамир, соёл, урлаг, амралт, хүүхэд, залуучуудын зэрэг төсвийн байгууллагын дарга;</li> <li>- Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн чанарын менежер;</li> <li>- Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн нэгжийн дарга;</li> <li>- Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн нэгжийн дарга;</li> <li>- Нислэгийн цаг уурын төвийн нэгжийн дарга; Нислэгийн цаг уурын төвийн чанарын менежер;</li> <li>- Аймаг, хотын Цаг уур, орчны шинжилгээний төвийн нэгжийн дарга;</li> <li>- Ламны орхлох асуудлын хүрээнд ажилладаг төрийн үйлчилгээний төсвийн байгууллагын ерөнхий инженер, урьдчилан сэргийлэхийн технологич инженер, лабораторийн эрхлэгч, алба, нэгжийн дарга;</li> <li>- Үндэсний төв архивын нэгжийн дарга, эрхлэгч;</li> <li>- Орон нутгийн биеийн тамир, соёл, урлаг, амралт, хүүхэд, залуучуудын зэрэг төсвийн байгууллагын дарга;</li> <li>- Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн нэгжийн дарга, чанарын менежер.</li> </ul>
-----------------------------	--

---oOo---